



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 10 сарын 22 өдөр

Дугаар А/31.

Мөрөн сум

Ур чадварын нэмэгдэл олгох тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, Боловсрол Шинжлэх Ухааны сайд, Нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/35, А/10/9 тоот тушаалын 4.2, 4.5 дах заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дотуур байрын багш Түдэвдорж овогтой Баттуяа нь сурагчдын эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд санаачлагатай ажиллаж дотуур байрын гадна тохижилт, амрах тоглох, чөлөөт цагаа өнгөрөөх орчныг зөв шийдэл, шинэлэг байдлаар шийдэж үр дүнд хариуцлагатай ажилласан. Мөн сургуулийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн даргын ажлыг хавсран гүйцэтгэж эд хөрөнгийг цахим системд оруулах ажлыг гардан хариуцлагатай хийж байгаа тул үндсэн цалингийн 20 хувиар тооцож 3 сараар олгосугай.

2. Ур чадварын нэмэгдлийг зохих журмын дагуу бодож олгохыг нягтлан бодогч Цогт-Эрдэнэ овогтой Уугантуяад зөвшөөрсүгэй.

ЗАХИРАЛ



М. АРИУНАА